

СУМЫН ХАРЬЯА ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГУУДЫН 2023 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН
ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ,
ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Зорилго:Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрээр өгөгдсөн үүрэг, даалгаврын биелэлт, байгууллагын чиг үүргийн болон нээлттэй байдлын үзүүлэлтүүдэд хяналт-шинжилгээ хийж, гүйцэтгэлийн үр дүнг үнэлэх, гарсан дүгнэлт зөвлөмжийг дараагийн шийдвэр бодлого төлөвлөлтөд тусгах, үр нөлөөг нэмэгдүүлэх, хэрэгжилт зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулахад хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго оршино.

Үндэслэл арга зүй: Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоол, аймгийн Засаг даргын 2021 оны А/343 тоот захирамжаар баталсан журмын дагуу тус сумын харьяа төсөвт байгууллагуудын 2023 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээний хийлээ.

Баруун-Урт сумын Засаг даргын 2023 оны 05 сарын 30-ны өдрийн А/162 тоот захирамжаар томилогдсон ажлын хэсэг тус сумын харьяа төсөвт байгууллагуудын 2023 оны хагас жилийн үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, зөвлөгөө өгч ажиллалаа.

Хяналтыг 9 чиглэлээр, 2 хэсэг гарч 8 хүний бүрэлдэхүүнтэй хийсэн.

Хяналтаар дараах баримт бичгийг хэрэгжилтийг үзлээ.Үүнд:

- 1.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт
- 2.Тусгай захиалгат бүтээгдэхүүний хэрэгжилт
- 3.Тушаалын хууль эрх зүй үндэслэл
- 4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт
- 5.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайлан
6. Байгууллагын төсөв, санхүү, тендер, хөрөнгө оруулалт
- 7.Хүүхэд хамгааллын багийн төлөвлөгөө, хэрэгжилт
- 8.Цаг үеийн асуудлаар өгсөн үүргийн биелэлт
- 9.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хяналтад авсан байдал

1. Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, хяналтад авсан байдал:

Нийтлэгээр байгууллагын хяналтад байх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг тусгайлан жагсаалт үйлдэж, хяналтад аваагүй. Боловсролын яамны сайдын тушаалыг

хяналтад авч, хэрэгжилтийг хангаж ажилласан байна.Иймд хяналтад байх хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн жагсаалтыг гарган өгч, хяналтад авч ажиллахыг зөвлөсөн.

Нийт 19 байгууллагаас

2. Тушаалын хууль эрх үзүй үндэслэлд хяналт хийх.

Тушаалын хууль эрх зүйн үндэслэлд хяналт хийхэд хууль үндэслэхгүй шийдвэр гаргах, өөрт хамааралгүй буюу бүрэн эрх олгоогүй хууль үндэслэж шийдвэр гаргасан, хууль эрх зүйн эрэмбэ дарааллын алдаатай, эрүүл мэндийн хуудас үндэслэсэн, зөв бичиг болон найруулга зүйн зөрчилтэй байна.Үүнд:

Хүний нөөцтэй холбоотой тушаалаа А-гаар дугаарласан.

Тушаалын хавсралт байхгүй.

Тендерийн үнэлгээний хороо байгуулсан захирамж хүчин төгөлдөр бус, эрх олгоогүй хууль үндэслэж гаргасан.

Үг үсэг, найруулга зүйн алдаатай.

Тушаалын бүртгэл хөтлөөгүй.

Тушаалын тэргүүг оновчтой томъёолоогүй.

Хөдөлмөрийн тухай хуулиар хөдөлмөрийн харилцаагаа зохицуулж, тушаал шийдвэрийг гаргах ёстой боловч ажилд томилох, чөлөөлөх тухай гэж төрийн албаны тухай хуулийн үг хэллэг ашигласан байсан.

Хоёр шийдвэрийг нэгтгэж нэг шийдвэр болгож гаргасан.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болсон хугацаагаар шийдвэрийг баталгаажуулсан зэрэг байх зэрэг зөрчил илэрсэн байна.

Зөвлөмж:

Тушаалын агуулга нь учир зүйн дэс дараалалтай, албан үг хэллэг хэрэглэж, үг үсэг, найруулга зүйн алдаагүй эрх зүйн шийдвэр гаргаж хэвших.

Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа эхэлсэн болон дууссан хугацаагаар тушаалыг тухай бүр төлөвлөж хэвшүүлэх.

Албан бичгээ хос бичгээр хөтөлж эхлэх 2023 ондоо багтаан А,Б тушаалаа төлөвлөж эхлэх.

3.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын хэрэгжилтийн тайлан

Засгийн газрын 2022 оны 352 дугаар тогтоолоор "Нээлттэй мэдээллийг ил тод байлгах болон ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам батлагдсан. Үүнтэй холбоотойгоор 2023 оны эхний хагас жилийн хяналт шинжилгээ үнэлгээний ажлын хэсэг журмын танилцуулж, хяналтад авч ажиллах тухай зөвлөгөө өгч ажилласан.

Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг 5 чиглэлд 26-40 арга хэмжээг хяналтад авч, биелэлтийг тооцож гаргасан боловч, аргачлалын дагуу үнэлээгүй байсан. Нээлттэй мэдээллийг цахим хуудаст болон мэдээллийн самбарт хагас дутуу байршуулсан бусад мэдээллийн хэрэгсэл ашиглаж нийтлээгүй байсан.

Зөвлөмж:

Нээлттэй мэдээллийн ил тод байдлыг хяналтад авч хэрэгжилтийг тайлагнаж, үнэлгээний аргачлалын дагуу үнэлж дүгнэсэн байх.

Самбар болон цахим хуудас, бусад мэдээллийн суваг ашиглан мэдээллийг түгээх, байршуулсан мэдээллээ нотлох баримтуудыг хавсаргасан байх.

Иргэний мэдээлэл хайх, хүлээн авах эрхийг хангах, байгууллагын үйл ажиллагааг цахим хэлбэрээр явуулах, нээлттэй, ил тод, шуурхай байлгахад анхаарч ажиллах.

4.Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн биелэлт

Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг 2 зорилт 27 заалтын хэрэгжилтийг хянан үзэхэд дараах зөрчил илэрч байна Үүнд :

Уртын гэгээ ОНӨААТҮГ, Баруун-Урт цэцэрлэгжүүлэлт ойн анги ААТҮГазрууд нь сургалт хөгжил, нийгмийн баталгааг хангах чиглэлээр ажил арга хэмжээ санаачлан хийдэг боловч төлөвлөгөө гаргаж батлуулаагүй.

Сургууль цэцэрлэгүүд төрийн албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах орчин, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөө гарган батлуулаагүй.

Багш хөгжлийн хөтөлбөр хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу ажилладаг.

Зөвлөмж

Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах орчин нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн хүрээнд төлөвлөгөө тухайн оны 1 дүгээр улиралд багтаан баталсан байх. Төрийн албан хаагчийн сургалт хөгжил, ажиллах орчин нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийн тухайн оны хүрэх түвшингээ тодорхойлж, сумын Тамгын газарт хүргүүлж сумын хэмжээний зорилтот түвшинд оруулж байх.

Аймгийн Засаг даргын 2021 оны А/343 дугаар захирамжаар батлагдсан журмын 10 дугаар хавсралт маягтын дагуу тайлагнах.

Төлөвлөгөөний биелэлтийг тайлагнахад тавигдах шаардлагыг хангаж тайлагнах Тайлан иж бүрэн, алдаа мадаггүй, бодитой, итгэл үнэмшил төрүүлэхүйц, аль болох товч, тодорхой байх ёстой

Тайлагнахдаа дараах асуудлыг заавал тусгасан байна.

Тухайн ажлын гүйцэтгэл нь төлөвлөсөн үр дүнд хүрсэн эсэх

Төлөвлөсөн үр дүнд хүрээгүй бол түүний шалтгаан, нөхцлийг тодорхой дурдах

Сургалтын нэгдсэн бүртгэлийг цахимаар эсвэл цаасан хэлбэрээр хөтөлж хэвших, түүндээ зураг хавсаргах нотлох

5.Удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт

Тус Тамгын газраас цаг үеийн асуудлаар өгсөн 7 үүргийг биелэлтийг хянан үзлээ. Үүнд:

1. Тэр бум мод
2. Бүх нийтийн цэвэрлэгээ
3. Цас цэвэрлэгээ
4. Сээ зэм
5. Гамшгийн үеийн бэлэн байдал-
6. Оготно устгал
7. Тоолуур тавиулах-11

Тамгын газраас өгсөн үүргийг цаг тухай бүр нь биелүүлж ажилласан.

Тэр бум мод үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд төсөвт үүнтэй холбоотой зардал тусгаагүй, багш ажилчдаас мөнгө хураах хориотой, мод арчилгаа, хамгаалалт байхгүй тул ургалтын хувь бага байна.

6.Төсөв санхүү, худалдан авах ажиллагаа

1. Үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэгүүд он, сар, зөрүүтэй, гарын үсэг зуруулж хэвшээгүй байгаа тул үнэлгээний хорооны тушаал гарсан өдрөөр гарын үсэг зуруулаагүй байна.
2. Үнэлгээний хорооны гаргасан шийдвэр хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд үнэлгээний хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, бүх мэдээллийг агуулсан байх учир хурлын тэмдэглэл үйлдээгүй, гарын үсэг зурж баталгаажуулаагүй байна.
3. Тендерийн үнэлгээний заавар"-ыг мөрдөж ажилладаггүй. Иймд цаашид бүх маягтыг бөглөж үнэлгээний хорооны бүх гишүүдээр гарын үсэг зуруулж, үнэлгээний маягтыг хөтлөөгүй байна.
4. Харьяа төсөв байгууллагуудын шилэн дансны хэрэгжилтийг хянан шалгаж үзэхэд 9 дүгээр цэцэрлэгээс бусад газрууд хуулийн дагуу мэдээллийг 100 хувь хугацаандаа байршуулсан боловч шилэн дансны тухай хуулийн 4.1.9 – т зааснаар хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж сонгон шалгаруулсан бол тендерийн ерөнхий мэдээлэлийг оруулж байх бүлгийг хамааралгүй бүлэг гэж авч үзэж мэдээлээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна.
5. Тендерт шалгарсан Өсөх дэлгэр ундрах ХХКомпанитай байгуулсан бэлэн бүтээгдэхүүн худалдан авах гэрээ хийсэн боловч гэрээний хугацаа, гэрээний төлбөр зэргийг тусгаагүй зэрэг алдаа байхад хянан үзээгүй баталгаажуулсан байна.
6. Ерөнхий боловсролын бүрэн дунд сургууль болон СӨБ-ын байгууллагууд уран чадвар олгосон байдал: Үүнд

Багш ажилтны ур чадварыг үнэлж дүгнэхдээ сар бүр ур чадвар нэмэгдэл олгох тухай тушаал гарсан боловч хавсралтыг 9 дүгээр цэцэрлэгээс бусад газар гаргаагүй мөн нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Сүхбаатар тохижилт үйлчилгээ ОНӨААТҮГ, Уртын гэгээ ОНӨААТҮГ, Баруун-Урт ойн цэцэрлэгжүүлэлт анги ОНӨААТҮГ газруудад гарсан нийтлэг зөрчил

ОНӨААТҮГазрууд нь бараа материал худалдан авахдаа шууд худалдан авалтын журмыг баримталдаггүй санхүүжилтийг шууд хийж худалдах худалдан авах гэрээ байгуулаагүй, ажлын хэсэг байгуулж, акт үйлдээгүй зэрэг зөрчлүүд илэрсэн.

Баруун-Урт цэцэрлэгжүүлэлтийн ойн анги ОНӨААТҮГазар санхүүгийн анхан шатны баримтыг үзэж танилцахад бараа материал болон шатахууны зарцуулалтын тооцоог тухай бүр хөтлөж хэвшээгүй, гарын зурж баталгаажуулаагүй зэрэг зөрчлүүд илэрсэн байна

Зөвөлмж

Худалдан авах ажиллагаа

1. Худалдан авах ажиллагааны цахим системээр тендер шалгаруулалт зохион байгуулах, холбогдох мэдээллийг зарлан мэдээллэх журмын 3.2.7 Үнэлгээний хороо хуулийн 29.1-д заасан мэдэгдэл хүргүүлсэн өдөрт багтаан цахим системд тендер шалгаруулалтын үр дүнг үнэн зөв, бүрэн нийтэлж, захиалагчийн шийдвэрийн хуулбар шалгарсан тендерт оролцогчийн ирүүлсэн тендеийн нууцлаагүй хэсгийг Сангийн сайдын 2019 оны 06 дугаар сарын 04-ний өдрийн 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендер оролцогчдод ил болгох журам”-ын дагуу тендер шалгаруулалтын үр дүнг мэдэгдэл гарсан өдрөөр цахим системд оруулж хэвших.
2. ТБОНӨХБАҮХАТХуулийн 47 дугаар зүйлийн 47.7-д “Үнэлгээний хорооны гаргасан шийдвэр /цаашид үнэлгээний дүгнэлт гэх/ хурлын тэмдэглэл хэлбэртэй байх бөгөөд үнэлгээний хорооны гишүүдийн олонх дэмжиж гаргасан шийдвэр, түүний үндэслэл, бүх мэдээллийг агуулсан байна гэж заасныг мөрдөх.
3. 2012 оны Сангийн сайдын 194 дүгээр тушаалаар батлагдсан “Тендерийн үнэлгээний заавар”-ыг мөрдөж ажилладаггүй. Иймд цаашид бүх маягтыг бөглөж үнэлгээний хорооны бүх гишүүдээр гарын үсэг зуруулж байх.
4. Улсын Их хурлын Хууль зүйн байнга хорооны 2012 оны 05 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралт батлагдсан “Ашиг сонирхолын зөрчилгүй гэдгээ илэрхийлэх, зөрчил үүссэн тухай мэдэгдэл”% үнэлгээний хорооны гишүүнээр ажиллахыг зөвшөөрсөн мэдүүлэгүүд он сар зөрүүтэй, гарын үсэг зуруулж хэвшээгүй байгаа тул үнэлгээний хорооны тушаал гарсан өдрөөр гарын үсэг зуруулж байх.
5. 2021 оны Засгийн газрын 124 тоот тогтоол, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.1, 8.3 дугаар зүйлийг баримтлан шууд худалдан авалт зохион байгуулахдаа худалдах, худалдан авах гэрээ хийж, ажлын хэсэг байгуулж, акт, тэмдэглэл үйлдэх.
6. Дээрх өгсөн зөвлөмжийг 2023, 2024 оны хоол хүнсний худалдан авах ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллана уу.

Шилэн данс:

1. Шилэн дансны тухай хуулийн 4.1.9 – т зааснаар хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээг тендер зарлаж сонгон шалгаруулсан бол тендерийн ерөнхий мэдээлэлийг тендерийн хорооны дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор энэхүү журмын 7 дугаар хавсралтад заасан маягтын дагуу оруулж байх

Ур чадвар:

1. Багш ажилтаны ур чадварыг хагас жил тутамд үнэлж, нэмэгдэлийг сар бүр олгож байх.
2. Шалгуур үзүүлэлтийн үнэлгээгээр 60 хувь болон түүнээс дээш хувийг хангасан багш, ажилтанд тухайн жилийн батлагдсан төсөвт багтаан ур чадварын нэмэгэл олгох
3. Багш ажилтны ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдлийн хэмжээг тогтоох, нэмэгдэл олгох асуудлыг тухайн байгууллагын удирдах албан тушаалтны шийдвэрээр байгуулсан ажлын хэсгийн санал, дүгнэлтийг үндэслэн төсвийн ерөнхийлөн захирагч шийдвэрлэнэ.
4. Ур чадварыг үнэлж дүгнэх, нэмэгдэл олгох, үйл ажиллагаа нь ил тод нээлттэй, шударга, хамтын оролцоог хангасан, ашиг сонирхолын зөрчлөөс ангид байх

7.Хүүхэд хамгааллын багийн төлөвлөгөө, хэрэгжилт

- Хүүхдийн хөгжил хамгааллыг дэмжих зорилтот жилийн хүрээнд сургууль, цэцэрлэгүүд төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.
- Хүүхэд хамгааллын багийн төлөвлөгөөний хэрэгжилт 60-85%-тай хэрэгжиж байна.
- Эрсдэлт нөхцөлд амьдарч байгаа хүүхдүүдийн судалгааг гарган кейс нээн ажиллаж байна.

8.Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөө

Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулж байна. Төлөвлөгөөний хэрэгжилт.....хувьтай байна. Хэрэгжилт удааширсан ажил, арга хэмжээг эрчимжуулж ажиллах чиглэл өгч ажиллалаа.

9.Тусгай захиалгат бүтээгдэхүүний хэрэгжилт

Тусгай захиалгатаар нийт ...ажил нийлүүлснээс

Удааширсан....., татарсан, хугацаа болоогүйарга хэмжээ байна.

10.Байгууллагын дотоод хяналтын төлөвлөгөө, хэрэгжилт

Байгууллагын дотоод хяналтын ажлын хэсгийг тушаалаар томилон, төлөвлөгөө гарган баталж, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Хяналтыг удирдамжийн дагуу хийж, зөрчил илрүүлэн, арилгаж хэвшсэн байна. Зөвлөмж, илтгэх хуудсыг албажуулж,

Давуу тал

Өндөр эрсдэлтэй хүүхдүүдэд кейс нээж ажиллаж байна. Нийт- 24 хүүхдэд кейс нээсэн байна.

2 дугаар цэцэрлэг: Олон Улсын төсөл хөтөлбөрөөр гал тогооны тоног төхөөрөмжийг шинэчилсэн. 16,0 сая төгрөг

11 дүгээр цэцэрлэг: Тайлангуудыг QR коджуулсан байна. Олон Улсын төсөл хөтөлбөрөөс нийт 30,0 сая төгрөг татсан.

1-р сургууль: Сургуулийн 34 анги, танхимыг эцэг эхийн дэмжлэгтэйгээр засвар үйлчилгээг хийж байна. Эрсдэлт бүлгийн 270 өрхөд амьдарч байгаа хүүхдүүдийн эцэг эхчүүдэд хүүхэд хөгжил хамгааллын сургалтын зохион байгуулж эрсдэлийг бууруулах

мэдээ мэдээллийг хийсэн. Мөн эрсдэлт бүлгийн 270 хүүхдийг эрүүл мэндийн үзлэгт хамруулан 2-3 дах шатлалын эмнэлэгт -11 хүүхдийг холбон зуучлан ажилласан байна.

2-р сургууль: Хүүхэд хөгжлийг дэмжих жилийн хүрээнд төлчин сурагч, намрын ажил, сурагч цэрэг, бид сайн үйлстэн, өв тээгчтэй уулзах цаг зэрэг арга хэмжээг санаачлан зохион байгуулсан байна.

Эрсдэлт бүлгийн судалгаа, Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн судалгаа, Дотуур байранд амьдардаг хүүхдийн судалгаа, Хараа хяналт сул хүүхдүүдийн судалгаатай.

Санал хүсэлт

10 дугаар цэцэрлэг: Гудамжны гэрэлтүүлэг, нохой устгуулах, Гудамж бороо орсон үед явах боломжгүй шалбааг их тогтож байна. Цэцэрлэгийг нийтийн шугам сүлжээнд холбуулах, ундны усны асуудал хүнд байна. Агааржуулалтгүй нэг анги байна. Цаашид стандартын цэцэрлэгт орох шаардлагатай байна.

7-р цэцэрлэг: Засвар үйлчилгээний үлдэгдэл 2,7 сая төгрөг өр үүссэн, Дулааны тоолуур тавиулах

1- р сургууль: Сургуулийн урсгал засварт 6,0 төгрөгийн дэмжлэг хэрэгтэй байна. Сургуулийн ачааллыг бууруулах, Хосолсон сургалтын анги танхимыг шинээр нэмэгдүүлэх. 2025 онд сургуулийн 100 жилийн ой болно. Их засвар үйлчилгээг хийхэд дэмжлэг

2- р сургууль: Анги танхимуудын цонхны ризен солих шаардлагатай байна. Сургуулийн урсгал засварт 5-6 сая төгрөг шаардлагатай байна.

4-р сургууль: Урсгал засварын зардал 10,0 сая төгрөг хэрэгтэй байна. Усны зардал өр үүссэн.

4р сургуулийн дотоод хяналтын гишүүд онцгой байдлын газартай хамтран дотоод гадаад нөхцөл байдлын үнэлгээ хийлгүүлэн дотоод 7 зөрчлийг илрүүлэн арилгаж ажилсан байна. дотоод хяналтын улаан,шар, ногоон 3 өнгийн карттай их зөрчилтөй бол улаан зөрчилгүй бол ногоон гэх мэтээр өгч 3 хонгийн хугацаанд зөрчил дутагдалаа арилгаж ажилдаг байна.

Хяналт-шинжилгээ, үнэлгээний мөрөөр дараах зөвлөмжийг хүргүүлж байна.Үүнд:

Хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримтыг бичгийг бүрэн хяналтад авах, хэрэгжилтийг үр дүнтэй зохион байгуулах.

Засгийн газрын 2020 оны 217 тоот тогтоол, аргачлал, загвар батлах тухай ЗГХЭГ-ын даргын 2020 оны 100 дугаар тушаал судлах, гүйцэтгэлийн тайлан, төлөвлөгөө боловсруулах, гүйцэтгэлийн тайлан бичих чиглэлээр тусгайлан сургалт, зөвлөгөө авах.

ЗГ-ын 2022 оны 352 дугаар тогтоолоор нээлттэй мэдээллийг ил тод байлгах ил тод байдлын шалгуур үзүүлэлт тогтоох, үнэлгээ хийх журам батлагдсан.Тогтоолуудыг хяналтад авч, хэрэгжилтийг зохион байгуулж ажиллах.

Шилэн дансны тухай хуулийг чанд мөрдөн ажиллаж, тогтоосон хугацаанд холбогдох мэдээллийг цахим хуудсанд иж бүрэн, үнэн зөв мэдээлж, мэдээллийн ил тод байдлыг хангаж ажиллах.

Баримт бичиг боловсруулах, судалгаа, баримт, нотолгоонд тулгуурлан тайлагнах ур чадварыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллах.

Нэг ажил үйлчилгээ, арга хэмжээний гүйцэтгэлийг 2000 тэмдэгтэд багтааж тайлагнана.

Тайлан бичсэн:

Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн

А.Өлзийжаргал